

Түүх 4: Мосе 1

Библийн эшлэл
[Гэтлэл 2:106]

Мөнөөх нь хүүг Мосе гэж нэрлээд, учир нь би түүнийг уснаас гаргаж авсан юм гэж хэлжээ.

Израиль хүмүүс Египетэд амьдраад дөрвөн зуун жил болжээ.

Израильчууд Бурханы ивээлээр Египет газрыг дүүртэл хүн амын тоо ихээр өсчээ.

Үүнд Египетийн хаан Фараоны санаа нь ихэд зовж эхлэв.

Тэгээд Фараон хаан Израильчуудыг боол болгон, тэднийг ихэд дарамталж байлаа.

Хэдийгээр Египетчүүд тэднийг дарамтлан зовоож байсан ч тэгэх тусам тэд Бурханы ивээлээр бүр ч ихээр олширч олуулаа болж байлаа.

Гэтэл нэгэн өдөр, Египетийн хаан Фараон эх баригч эмч нарыг ордондоо дуудав.

Эх баригч эмч нар бол мэндэлж байгаа хүүхдийг эх барьж авдаг хүмүүс юм.

Фараон хаан ийм тушаал буулгав. Израиль эмэгтэйчүүдийг амаржихад нь охин байвал амьд үлдээ, хэрэв хүү байвал зайлшгүй Нил мөрөн рүү шидэж устга! гэв.

Гэвч эх баригчид Бурханаас эмээж мэндэлсэн хөвгүүдийг амьд үлдээв.

Тийм ч учраас Бурхан эх баригчдыг ерөөжээ.

Харин Бурхан, Израильчуудын залбирал болон зовж шаналсан хашгирааныг сонсож Израиль ард түмнээ аврахаар төлөвлөжээ.

Нэгэн Израиль эмэгтэй хүү төрүүлжээ.

Тэр эмэгтэй хүүг харахад маш царайлаг, хайр хүрэм байсан тул хүүг гол руу шидэж чадахгүй байлаа.

Тиймээс хүүгээ гурван сарын турш хүүг нууцаар өсгөжээ.

Хүү өсөх тусам уйлах дуу нь чангарч байсан тул цаашид нуун өсгөх боломжгүй болжээ.

Хүүгийн ээж зовж шаналан үйлж Бурханд залбирав.

Эцэст нь эмэгтэй зэгсээр сагс хийж барагшин болон давирхайгаар шавж ус нэвтрэхгүй болгоод хүүгээ сагсанд хийв.

Тэгээд түүнийгээ Нил мөрний эрэг дагуу тавьжээ.

Хүүгийн төрсөн эгч Мириам зэгсэн дундаас дүүгээ ажиглан харж байв.



Хүүг хийсэн зэгсэн сагс хөвөн хөвсөөр Фараон хааны гүнжийн усанд орж байгаа газар ирээд тогчихов.

Гүнж, усан дээр хөвж байгаа сагсыг олж харав.

Тэд үед бүхнийг нуугдан харж байсан Мириам гүнж рүү гүйн очлоо.

Мириам, Гүнжтэн минь хүүг асрах хүнийг би танд олж өгөх үү?

Гүнж ингэж хариулав. “Тэгвэл сайн байна.”

Мириам бөөн баяр хөөр болон гүйсээр гэртээ ирэв.

Тэгээд ээждээ болсон бүхнийг хэлэв.

Хүүгийн ээж хамаг хүрдаараа гүйсээр гүнж дээр ирэв.

Ийнхүү Бурхан бяцхан хүүг ээжтэйгээ хамт өсөх боломжийг өгчээ.

Фараоны гүнж хүүг Мосе гэж нэрлэжээ. Мосе гэдэг нь “уснаас гаргаж авсан” гэсэн утгатай байлаа.

Мосе өсөж том болжээ.

Асрагч эх болох хүүгийн төрсөн ээж нь Мосег өсгөхдөө Бурханы хүн байх итгэлийг суулгаж өгсөн юм.


Мосе гүнжийн хүү болж, бусад ханхүү нарын адлилаар ордонд олон мэдлэг боловсролыг эзэмшсээр байлаа.

Хожмын өдрүүдийн төлөө Бурхан Мосег Израильчуудыг удирдан хөтлөх агуу удирдагчаар бэлдсэн юм.

Мосе Бурханы айлдсаны дагуу Египетэд ядарч, зүдэрч байгаа Израиль ард түмнийг удирдан төрсөн нутаг руугаа явсан юм. Ингээд Израильчууд Бурханд хүндэтгэл мөргөл өргөж чадах эрх чөлөөтэй хүмүүс болжээ.

- Дараах эшлэлийг дагаж бицээд цээжлээрэй. (Гэтлэл 2:106)

Мөнөөх нь хүүг Мосе гэж нэрлээд, учир нь би түүнийг уснаас гаргаж авсан юм гэж хэлжээ.



Үйл ажиллагаа 1.

Хүү Мосег болон сэгсийг өнгөөр ялган будаж, бас өнгийн цаасаар чимэглэн наагаарай.
(Хэрэглэгдэх материал: Өнгийн харандаа, өнгийн цаас, хайч, цавуу)

